

2020 оны 10 сарын 14 өдөр

БАТЛАВ  
"ЖИ БИ ЭС ИМПЭКС" ХХК-НИЙ  
ЗАХИРАЛ Д. БАТБАЯР

## ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

№ 154

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээг нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар /цаашид Захиалагч гэх/, нөгөө талаас "Жи Би Эс импэкс" ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/, харилцан зөвшилцөн Иргэний хуулийн 476 дугаар зүйлийн 476.1, 476.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.8 дахь заалтыг үндэслэн харилцан тохиролцож дор дурдсан нөхцөлөөр энэхүү "Үйлчилгээ үзүүлэх гэрээ" (цаашид гэрээ гэх)-г байгуулав.

1.2. Хамтран ажиллах гэрээг бичгээр байгуулна.

1.3. Энэхүү гэрээгээр коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын голомттой улс орноос ирсэн эмнэлзүйн шинж тэмдэггүй иргэнийг түр тусгаарлан эмчийн хяналтанд тусгаарлах ажиглалт үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.

1.4. Тусгаарлах, ажиглах байранд халдварын эрсдэлийг тооцон иргэнийг эмчийн хяналтанд 21 хоног тусгаарлана.

### Хоёр. Талуудын эрх, үүрэг

#### 2.1. Захиалагч дараах эрх, үүргийг хүлээнэ.

2.1.1. Захиалагч тал тусгаарлах, ажиглах байранд тусгаарлах иргэнийг зохих журмын дагуу аюулгүй байдлыг ханган хүргэнэ.

2.1.2. Тусгаарлах, ажиглах байранд тусгаарлах хүний тоог урьдчилан төлөвлөж, аж ахуйн нэгж байгууллагын ажиллагсад халдварын сэргийлэлт хяналттай холбоотой зохих мэдээллийг өгч, сургалт зохион байгуулна.

2.1.3. Урьдчилан бэлтгэлийг хангуулах зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын гаргасан хүлээлт үндэслэн шаардлагатай тохиолдолд урьдчилгаа төлбөрийг шилжүүлж болно. (нийт төлбөрийн 70 хувь хүртэл)

2.1.4. Тусгаарлах, ажиглах байрыг Цагдаагийн байгууллагын хяналтанд байлгаж аюулгүй байдлыг хангана.

2.1.5. Тусгаарлагдсан иргэдийн эрүүл мэндэд хяналт тавих эмч томилон ажиллуулна.

2.1.6. Гэрээний үүргийн хугацаа дуусгавар болсоны дараа төлбөрийн үлдэгдлийн зохих хувийг гүйцэтгэлээр тооцож шилжүүлнэ.

2.1.7. Тусгаарлах, ажиглах байрны өрөөний эд хөрөнгө, тавилга хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг захиалагч тал хариуцахгүй.

1 2

3 4

2.1.8. Захиалагч тал нь Гүйцэтгэгч талаас үйлчилгээний болон хоолны чанар стандартыг хангуулах зорилгоор шаардлага тавьж болно.

## **2.2. Гүйцэтгэгч тал дараах эрх, үүргийг хүлээнэ.**

2.2.1. 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн Монгол Улсын Шадар сайдын “Үнэ тогтоох тухай” 23 дугаар тушаалд заасан төлбөрийг тусгаарлагдсан иргэдийн тоогоор нэхэмжлэх эрхтэй.

2.2.2.Тусгаарлах, ажиглах байранд ажиллах үйлчилгээний ажилчдыг 21 хоног байршуулан ажиллуулна.

2.2.3.ХӨСҮТ болон бусад эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн шалтгаанаар шилжсэн иргэний төлбөрийг байрласан хоногоор тооцон тухайн байгууллагад шилжүүлнэ.

2.2.4.Шуурхай штаб, мэргэжлийн байгууллагаас өгсөн заавар, зөвлөмжийг чанд мөрдөж ажиллана.

2.2.5.Чанар стандарт, аюулгүй байдлын шаардлага хангасан, амт чанар, тэжээллэг хоолосор үйлчилнэ.

2.2.6.Хоол үйлдвэрлэл үйлчилгээний аюулгүй байдлыг хангана.

2.2.7.Хүнсний үйлчилгээний ажилтан, ажиллагсдыг ажиглалтанд байгаа хүмүүстэй харьцахгүй байхаар зохион байгуулна.

2.2.8.Үйлчилгээ, хоолны чанартай холбоотой гарсан гомдлыг тухай бүр нь дотооддоо шийдвэрлэн захиалагч талд мэдэгдэж ажиллана.

2.2.10. Захиалагчаас шаардсан мэдээллийг тухай бүрт нь үнэн зөв гаргаж хүргүүлнэ.

2.2.11. Гүйцэтгэгч талууд тэгш эрхтэйгээр үүрэг, хариуцлага хүлээнэ.

### **Гурав. Давагдашгүй хүчин зүйл**

3.1.Гэрээнд оролцогч талуудаас үл хамаарах байгалийн хүчин зүйлийн нөлөөгөөр талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй буюу зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар 24 цагийн дотор харилцан мэдэгдэх үүрэгтэй бөгөөд түүний улмаас ямар нэгэн хохирол учирсан тохиолдолд талууд хариуцлага үл хүлээнэ.

### **Дөрөв. Хариуцлага**

4.1.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн тохиолдолд гэрээг дуусгавар болсонд тооцно.

4.1.2.Хэрэв энэ гэрээнд заасан болон түүнтэй холбогдох асуудлаар маргаан гарвал талууд харилцан зөвшилцлийн замаар шийдвэрлэж чадахгүйд хүрвэл холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүх байгууллагаар шийдвэрлүүлнэ.



4.1.3.Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга дарснаар гэрээ хүчин төгөлдөр болсонд тооцож, тал тус бүр нэг хувийг хадгална.



**Тав. Төлбөр, төлбөр төлөх нөхцөл**

- 5.1 Гэрээний нийт төлбөрийг тооцоо нийлсэний үндсэн дээр тухай бүр тооцох болно.  
5.2. Энэхүү гэрээний төлбөрийг тусгаарлах байранд иргэдийг байршуулсанаас хойш ажлын 10 хоногийн дотор талууд тооцоо нийлж Хаан банкны 5020614976 тоот дансанд төлнө.  
5.3 Талууд тусгаарлах байрны төлбөрийг зориулалтын дагуу ашиглана.

**Гэрээ байгуулсан:**

<p><b>Захиалагчийг төлөөлж</b></p> <p>Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, хурандаа</p> <p style="text-align: right;">Г.Бат-Эрдэнэ (гарын үсэг)</p> <p>Хаяг: Партизан 6, Сүхбаатар Дүүрэг 5-р хороо, Улаанбаатар Төв, Монгол Улс</p> <p>Холбоо барих утас: 51-262489,</p> <p>Э-шуудан: obeg_sankhuu@yahoo.com ХАЯГ: ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР</p>	<p><b>Гүйцэтгэгчийг төлөөлж</b></p> <p>"Жи Би Эс Импэкс" ХХК-ний менежер Баярмагнай овогтой Адилцэцэг  (гарын үсэг)</p> <p>ХАЯГ: БГД 1-р хороо төмөр зам замчдын 48а УТАС: 93043737</p> <p><b>Гүйцэтгэгчийг төлөөлж</b></p> <p>Захирал Дүгэрсүрэн овогтой Батбаяр  (гарын үсэг)</p> <p>ХАЯГ: БГД 1-р хороо төмөр зам замчдын 48а УТАС: 99113113</p>
---	---

